

Умайн хүзүүний илрүүлгийн шинжилгээ гэж юу вэ?

Умайн хүзүүний илрүүлгийн шинжилгээ нь умайн хүзүүний эрүүл байдлыг шалгадаг. Умайн хүзүү нь үтрээнээс умай хүртэлх хооронд байрлах суваг юм. Умайн хүзүүний илрүүлэг нь умайн хүзүүний хорт хавдраас өөрийгөө хамгаалах хамгийн сайн аргуудын нэг юм.

Энэ нь хорт хавдрын шинжилгээ биш юм. Энэ нь хорт хавдар **үүсэхээс** урьдчилан сэргийлэх шинжилгээ юм.

Энэ нь умайн хүзүүний хорт хавдраас өөрийгөө хамгаалах хамгийн сайн аргуудын нэг тул умайн хүзүүний илрүүлгийн үзлэгт хамрагдах хугацааг хойшлуулж болохгүй.

Умайн хүзүүний HPV илрүүлэг гэж юу вэ?

Энэ нь умайн хүзүүний үзлэгийн **шинэ** арга барил юм. Умайн хүзүүний HPV үзлэгийг анх 2020 онд Ирланд улсад нэвтрүүлсэн. Энэ төрлийн умайн хүзүүний үзлэгийг Австрали, Нидерланд, Англи болон Уэльст орнуудад аль хэдийн нэвтрүүлээд байна. Таны умайн хүзүүний үзлэгийн дээжийг эхлээд умайн хүзүүний хорт хавдар үүсгэж болох хүний хөхөнцөр вирус (HPV) байгаа эсэхийг шалгана.

Хэрэв HPV вирус илэрсэн бол таны умайн хүзүүнд хэвийн бус (хорт хавдрын өмнөх) эсийн өөрчлөлт байгаа эсэхийг шалгахын тулд ижил сорьцыг авна.

Энэ төрлийн үзлэг нь:

- Умайн хүзүүний илрүүлгийн илүү сайн арга юм
- Илүү олон хорт хавдраас сэргийлдэг
- Зарим хүмүүс илүү цөөн шинжилгээ өгөх боломжтой болно гэсэн үг юм

Хэрэв урьд нь түрхэцийн шинжилгээ өгч байсан бол умайн хүзүүний илрүүлгийн шинжилгээ өгөх нь төстэй санагдаж магадгүй.

HPV умайн хүзүүний илрүүлгийн шинжилгээ хэрхэн хийгддэг вэ?

Илрүүлгийн шинжилгээ ихэвчлэн 5 минутын турш үргэлжилдэг.

1. Таниас бэлхүүснээс доошхи хувцасаа тайлж буйдан дээр хэвтэхийг асуух болно.
2. Та аль өөртөө тухтайгаар дээшээ харах аль эсвэл аль нэг талруугаа харж хэвтэж болно.
3. Эмч юмуу сувилагч үтрээнд тань багаж болох толийг зөөлхөнөөр хийнэ. Ингэснээр үтрээний ханыг нээлттэй байлгаж, умайн хүзүүг харах боломжтой.
4. Жижиг зөөлөн багс ашиглан умайн хүзүүний эсийн дээжийг зөөлөн цуглуулна.

Зарим хүмүүсийн хувьд энэхүү үйл явц нь тухгүй, ичмээр санагддаг ч ихэнх хүмүүст өвдөлтгүй байдаг. Хэрэв танд шинжилгээ өгөх үед өвдөлт мэдрэгдвэл эмч юмуу сувилагчдаа хэлээрэй, тэд таагүй байдлыг багасгах болно.

Умайн хүзүүний үзлэгийн ач тус нь юу вэ?

Энгийн HPV умайн хүзүүн үзлэг нь:

- Амь насыг авардаг
- HPV вирусыг умайн хүзүүнд хэвийн бус эс үүсгэхээс өмнө илрүүлж чадна

- Шинж тэмдэг илрэхээс өмнө хэвийн бус эсийг олж чадна
- Хялбар эмчлэгддэг тохиолдол байх үед хэвийн бус эсийн өөрчлөлтийг олж болно

HPV болон хэвийн бус эсийг аль болох эрт олох нь умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх хамгийн шилдэг арга юм.

Тийм учраас тогтмол үзлэг, шинжилгээ хийлгэх нь чухад юм.

Умайн хүзүүний үзлэгт ямар хязгаарлалтууд байдаг вэ?

Умайн хүзүүний үзлэгийн гол хязгаарлалтууд нь:

- Умайн хүзүүний үзлэг нь умайн хүзүүний хорт хавдрын тохиолдлуудаас урьдчилан сэргийлэхгүй
- Зарим хүмүүс тогтмол үзлэгт хамрагдсан ч умайн хүзүүний хорт хавдар илэрч болно
- Зарим хэвийн бус эсийн өөрчлөлтийг явцад орхигдуулах, бүх хэвийн бус эсийг илрүүлэхгүй байж болзошгүй.
- Заримдаа шинжилгээний үр дүн нарийвчлалтай гарахгүй байдаг

Миний дээж юу болох вэ?

Таны дээж чанарын баталгаатай лабораторилуу (Лаб) явна. Лаб-д дээжийг шинжлэн HPV вирусын халдвартай эсэхийг харна. Хэрэв идэвхитэй HPV вирус илэрвэл 2 мэргэжилтэн таны дээжийн эсийн өөрчлөлтийг шалгана. Хэрэв тэд ямар нэг өөрчлөлт олвол Дараагийн шатны шинжилгээ болох Колпоскопи хэрэгтэй болно. Колпоскопи нь таны умайн хүзүүг илүү нарийвчлан харах шинжилгээ юм.

Яагаад зарим хэвийн бус эсийн өөрчлөлтийг орхигдуулах боломж байдаг вэ?

Таны дээжийг эхлээд HPV шинжлэгдэх болно. HPV илэрвэл, хэвийн бус эсийн өөрчлөлтийг харах болно.

Гэвч умайн хүзүүний хорт хавдартай хүн бүр үзлэгийн явцад HPV вирус илэрдэггүй.

Сөрөг HPV шинжилгээ – HPV илрээгүй хүнд ирээдүйд халдвар авахгүй гэсэн баталгаа биш юм.

Хэвийн бус эсийн өөрчлөлт заримдаа орхигддог учир нь:

- заримдаа хэвийн бус эс хэвийн эс шиг харагддаг.
- Тийм дээжид дэх хэвийн бус эс маш цөөхөн тохиолддог
- Таны дээжийг уншиж байгаа хүн хэвийн бус эсийг орхигдуулах нь (тохиолдол байдаг ба туршлагаас хамаардаггүй)

Ямар нэг илрүүлгийн програмд шинжилгээ хамаарахгүй хүн бүрийн умайн хүзүүний хэвийн бус эсийг олж чадна

Умайн хүзүүний хорт хавдарыг илрүүлэхэд олон жил болдог. Ихэнх тохиолдолд, хэвийн эс хэвийн бус болтол 10-15 жил болдог.

Тийм учраас шаардлагатай гэж үзсэн үедээ умайн хүзүүний үзлэгт орж байх шаардлагатай.



Умайн хүзүүний үзлэг талаарх мэдээллийн хуудас

Шинжилгээний хариугаа хэрхэн авах вэ?

Хариуг тань шуудангаар илгээх болно, ихэвчлэн 4 долоо хоногийн дотор илгээдэг. Тэд мөн таны ерөнхий эмч (эмч) эсвэл эмнэлэггүй илгээдэг.

Миний шинжилгээний хариу ямар утгатай вэ?

Дөрвөн төрлийн боломжит хариу гардаг.

1. HPV илрээгүй

Таны хариунд HPV халдвар энэ удаа илрээгүй Таны дараагийн умайн хүзүүний үзлэгт орох хугацаа наснаасаа хамаараад 3-5 жилийн дотор байна.

2. HPV илэрсэн ба хэвийн бус эсийн өөрчлөлт олдоогүй

Таны хариунд HPV халвар илэрсэн гэхдээ хэвийн бус эсийн өөрчлөлт харагдахгүй байна. Та давтан шинжилгээнд орох хугацаа 12 сар Энэ нь та биеэсээ HPV халдварыг цэвэрлэх хугацааг олгоно

3. HPV илэрсэн мөн хэвийн бус эсийн өөрчлөлт илэрсэн

Таны хариунд HPV халдвар илэрсэн мөн умайн хүзүүнд хэвийн бус эсийн өөрчлөлт байна Та дараагийн шатны шинжилгээ өгөх шаардлагатай Колпоскопи - таны умайн хүзүүний илүү нарийвчилсан үзлэг Энэ нь умайн хүзүүний үзлэгтэй төстэй

4. Онцгой дээж

Энэ нь лаб таны үзлэгийн шинжилгээний дээжийг ашиглах боломжгүй болсон Та давтан шинжилгээг 3 сарын дотор өгөх хэрэгтэй болно.

Зөвшөөрлөө өгсөнөөр

Умайн хүзүүний үзлэгт орох тухай бүрт умайн хүзүүний шинжилгээний өмнө гарын үсэг зурж зөвшөөрхийг асуух болно. Хэрэв та маягт дээр гарын үсэг зурж чадахгүй бол эмч юмуу сувилагчийн нүдэн дээр дохио өгөх юмуу амаар зөвшөөрөл олгож болно.

Энэ таныг дараах зөвшөөрөл олгож байна гэж ойлгож болно:

- Умайн хүзүүний үзлэг болон түүний ач тус, хязгаарлалтуудын тухай ойлголт авсан
- Тэрхүү мэдээллийг ойлгосон
- Таны нэр, хаяг болон бусад мэдээллүүд үнэн зөв гэдгийг шалгасан (ингэснээр таньтай харьцаж болох зөв хаяг мөн эсэхийг баталгаажуулсан)
- Бидэнд таны хувийн мэдээллийг хадгалах, солилцох болон HPV умайн хүзүүний үзлэгийн програмд үзлэгийн түүхийг үүсгэх боломжийг олгох

Сануулга: Манай програмын хэсэг болох зөвшөөрлийг зөвхөн та олгож чадна. Үзлэгт орхоосоо өмнө зөвшөөрлөө олгох Үзлэг шинжилгээ Freephone **1800 45 45 55** or emailing **info@cervicalcheck.ie** хаягаар бидэнтэй холбогдож хүссэн үедээ хүсэлтээ буцаах боломжтой.

Ингэснээр бид умайн хүзүүний үзлэгийн програмын талаар дахин тантай холбоо барихгүй гэсэн үг юм.

Таны хувийн мэдээллийг бид хэрхэн ашиглах вэ

CervicalCheck нь таны хувийн мэдээллийг найдвартай хадгалдаг (нэр, хаяг, утасны дугаар, төрсөн он сар өдөр, үнэмлэхний дугаар, холбоотой эдгээдийн нэр) болон бусад түүхийг Таны умайн хүзүүний үзлэгийн түүх CervicalCheck-д оролцсоноор үүсэх болно.

Үүнд HPV умайн хүзүүний үзлэгийн хариу, Колпоскопи хамрагдалт, эмчилгээ болон биопси (шинжилгээний дээж)-ийн үр дүн зэрэг багтана.

Бид таны холбоо барих мэдээллийг таны дараагийн үзлэг шинжилгээний хуваарь эсвэл хариу гарах үед ашиглана. Бид мөн таны мэдээллийг бусад эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч програмыг хэрэгжүүлэгч газруудтай солилцоно. Үүнд үзлэг шинжилгээг авах эмч болон сувилагч, лаборатори, колпоскопи клиник болон Ирландын Үндэсний Хорт Хавдрын бүртгэлийн газар багтана. Энэ нь үйлчилгээний чанарыг хадгалах сайжруулахын тулд юм.

Бид үзлэг шинжилгээний дээжийг сургалтанд ашиглах магадлалтай байдаг, Хөтөлбөрийг чанар, үр нөлөөг шалгах, аудит хийх Бид мөн судалгаандаа таныг оролцуулах, таны мэдээллийг ашиглаж болно.

Үзлэгт хамрагдах үгүй нь таны сонголт юм. Бид таны нэрийг тайлан, сургалт болон шүүмж бичихдээ ашиглахгүй байх юм.

Бид таны хувийн мэдээллийг аюулгүй, найдвартай, нууцлалыг одоогийн өгөгдөл хамгаалах дүрэм журмын дагуу хадгалах болно.

Таны хүсэлтийн дагуу CervicalCheck-д хадгалагдаж буй хувийн мэдээлэлдээ бүрэн, нээлттэй хандах эрхтэй болно. Таны мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд CervicalCheck-д мэдэгдэх нь чухал юм. Өөрийнхөө бүртгэлд хандахыг хүсвэл hse.ie/gdpr/data-requests/ хаягаар харна уу.

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл HSE Privacy Notice - Patients and Service Users at hse.ie/gdpr/ хэсэгт хандана уу.

Тантай харилцахдаа

Дараах тохиолдолд бид тантай нээлттэй, шударга, цаг алдалгүй, ил тод харилцах болно:

- Танд ямар нэг зүйл дутагдалтай санагдвал
- Үйлчилгээний турш үр дүн хохиролтой тохиолдол гарвал
- Бид дараах тохиолдолд хохирол учирсан гэж тооцно

Тэгснээр бид таньд умайн хүзүүний үзлэгийн програмд оролцсоноор нарийн дээжлэгэрэнгүй мэдээллээр хангах болно.

Бид таны хариуг хүлээн авмагц ямар утгатай цаашид яах талаар мэдээллээр хангах болно. hse.ie/cervicalcheck хаягаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.





Дутуу бөглөсөн маягт буцаагдаж магадгүй

Маягт дээрх бүх мэдээлэл зөв эсэхийг үйлчлүүлэгчээс асууж баталгаажуулна уу.

Баталгаажуулсны дараа дээжийн хуруу шилний дугаарын шошгыг авч маягтанд хавсаргана уу.

Хуруу шилний дугаар:

А. Үйлчлүүлэгчийн мэдээлэл

Төрийн үйлчилгээний хувийн дугаар

СиЭсПиАйДи

Эмнэлгийн дугаар
(Боломжтой бол)

Төрсөн он сар өдөр

Овгийг ТОМООР ТУСАД нь бичнэ

Нэр

Дундах нэр

Төрөх үеийн овог

Эхийн охины нэр

Шуудангийн Хаяг Бүтэн (Хариу бичиг энэ хаягруу илгээгдэх болно)

Эйркод:

Харилцах утасны дугаар

В. Зөвшөөрөл

Дээрх миний мэдээлэл бүгд үнэн зөвийг шалгасан.

Надад танилцуулсан мэдээллийг би уншсан, ойлгосон. Би Умайн Хүзүүний оношлогоонд оролцохыг зөвшөөрч байна.

Харилцагчийн Гарын үсэг:

Умайн хүзүүний оношлогоо нь гэр бүлийн гишүүн аль эсвэл хууль ёсны асран хамгаалагч биш л бол зөвшөөрлийн хуудсанд гуравдагч этгээд баталгаа гаргахыг зөвшөөрдөггүй.

С. Гэрээт эмч эсвэл гэрээт эмнэлгийн мэдээлэл

Гэрээт эмчийн эмнэлгийн зөвлөлийн бүртгэлийн дугаар:

ЭСВЭЛ

Эмнэлзүйн код:

(КАН КОЛП ЖИН ППСС СТАЙ эсвэл ОНЖ)

Гэрээт Эмч эсвэл

Эмчлэгчийн Нэр:

Хаяг:

Утасны дугаар.

Д. Дээж авагчийн мэдээлэл

МСРН эсвэл НМБАЙ

Дээж авагчийн нэр:

Е. Умайн Хүзүүний Шинжилгээний мэдээлэл

Шинжилгээний огноо

Дээжийн байршил

☐ Савны хүзүү

☐ Хүнхэр (нийт умайн хагалгааны дараах)

Умайн хүзүү харагдаж байгаа тохиолдолд джжэ авагч нь умайн хүзүүг бүхэлд нь харж шүүр/сойзыг 5 x 360° эргүүлж сорьцыг зөв авах ёстой. Дээжийг ирүүлэх нь энэ үйлдлийг хийснийг баталгаажуулж байгаа явдал юм.

Г. Холбогдох эмнэлзүйн мэдээлэл

ЛМП

☐ ОСП/Даавар/
ЭйчАрТи

☐ Шилжүүлэн суулгахаас
өмнө/дараа

☐ Бэлгийн хавьтлын дараах цус
алдалт

☐ АйЮуСиДи

☐ Диализ

☐ Цэвэршилтийн дараах цус алдалт

☐ Цэвэршилтийн
дараах

☐ ХДХВ эерэг

☐ Дэд-нийт умайг авхуулах

☐ Нийт умайг арилгах

Г. Үзлэгийн болон Эмчилгээний Түүх

LABORATORY USE ONLY

ЗӨВХӨН ЛАБОРАТОРИЙН ХЭРЭГЦЭЭНД

Лабораторид хүлээн авсан огноо

Нэвтрэх дугаар

1°

2°

ТЗ эсүүд

Тийм ☐

Дугаар ☐

Тайлагнасан огноо

Гарын үсэг

Зам

Удирдлагын зөвлөмж